

Үхрүүдийг холбо

Өдөр бүр Фермер Жон өөрийн үхрийн эрүүл мэнд, байр байдлыг шалгахаар алхдаг.

Түүний үхрүүд 2 хэмжээст координатын бүхэл тоон цэгүүд дээр байх бөгөөд Фермер Жон координатын төв дээр байгаа.

Тэр замаа илүү сонирхолтой болгохын тулд зөвхөн координатын тэнхлэгүүдтэй параллель замаар л явдаг.

Цаашлаад, тэр зөвхөн аль нэг үхэр дээр очихдоо л чиглэлээ өөрчилдөг (тэр аль нэг үхэр дээр очоод чиглэлээ

өөрчилөхгүй байсан ч болно.) Тэр чиглэлээ 90 эсвэл 180 градусын өнцгөөр өөрчилж болно.

Фермер Жон бүх үхэр дээрээ очоод буцаад координатын төв дээрээ очих ёстой.

Фермер Жон өмнө нь очсон үхэр дээрээ хэдэн ч удаа очиж болох бөгөөд адилхан замыг урд хойноос нь 2 янзаар

тоолох бол бүх үхэр дээрээ очиж болох бүх замын тоог ол.

ОРОЛТ

Эхний мөрөнд бүхэл тоо.

Дараагийн мөрөнд үхэр бүрийн байршил болох бүхэл координат.

ЖИШЭЭ ОРОЛТ

4
0 1
2 1
2 0
2 -5

ГАРАЛТ

Фермер Жоны явж болох бүх замын тоог ол. (Явах замгүй бол 0 хэвлэж болно.)

ЖИШЭЭ ГАРАЛТ

2

ТАЙЛБАР

Фермер Жон 1 - 2 - 4 - 3 эсвэл 3 - 4 - 2 - 1 гэсэн замаар явж болно.

Орчуулсан : УБ 1-р сургуулийн 12-р ангийн сурагч Б.Мөнх-Оргил